



ЮНИТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ХХК-ИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1. 2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорино.

1.2.1. Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээлэлээр цаг хугацаанд нь хангах;

1.2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;

1.2.3. Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах;

1.2.4. Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах.

1.3. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомж, компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ

2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр хүргэнэ.

2.1.1. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;

2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;

2.1.4. Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;

2.1.5. Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;

2.1.6. Шаардлагатай бусад.

2.2. Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.

2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;

2.2.2. Санал бодлыг хүлээн авах;

2.2.3. Мэдээлэл хүргэх, солилцох;

2.2.4. Шаардлагатай бусад

ГУРАВ. БУСАД

3.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

3.2. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд компанийн ТУЗ-өөс хяналт тавина.

3.3. Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор компанийн ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

-ооо-